

БАТЛАВ  
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА БӨГӨӨД  
ШТАБЫН ДАРГА, ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ХУРАНДАА Т. БАТТОГТОХ

**ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР ХЭЛТСИЙН  
“ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВРАХ АНГИУДЫН АЛБАНЫ БЭЛТГЭЛ, БЭЛЭН БАЙДЛЫГ  
ДЭЭШЛҮҮЛЭХ” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Нэг: Зорилго**

Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймэр унтраах аврах ангийн алба хаагчдын Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гал түймэр унтраах дүрэм, Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх, гал түймэр унтраах гурван шатны дасгал сургуулийг чанаржуулах, гал унтраах тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, албаны бэлтгэл, бэлэн байдлын түвшинг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

**Хоёр: Хамрах хүрээ, нэгдсэн арга хэмжээ явуулах хугацаа**

“Албаны бэлтгэл, бэлэн байдлын түвшинг дээшлүүлэх” нэгдсэн удирдамжит арга хэмжээг 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 09 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэл хугацаанд зохион явуулна.

Нэгдсэн арга хэмжээнд төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн харьяа Гал түймэр унтраах аврах ангиуд хамрагдана.

**Гурав: Зохион байгуулах ажлын чиглэл:**

Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсүүд удирдамжийн дагуу дараах ажлыг зохион байгуулна.

1. МУ-ын Засгийн газар болон Шадар сайдын 2016 онд шинээр батлуулан гаргасан Гал түймэр унтраах дүрэм болон шинээр олгогдсон автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг аюулгүй ажиллуулах, засвар үйлчилгээ хийх дадлага олгох чиглэлээр танхимын болон дадлага олгох сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах.

2. Төв, орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагатай хамтран Онцгой байдлын газрын алба хаагчдыг эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт хамруулж гал түймэр унтраах үйл ажиллагаанд оролцох явцад бэртэж, гэмтсэн алба хаагчдын судалгааг гаргах, хэрэв эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт хамруулсан бол энэ тухай илтгэх хуудсаар ирүүлэх.

3. Намрын хуурайшилтын улирал эхэлж объектын болон ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан гал унтраах бэлтгэл бэлэн байдлыг сайжруулах зорилгоор гал унтраах автомашинд байршуулах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн иж бүрдлийг ханган, засвар, үйлчилгээ хийх.

4. ОБЕГ-аас шинээр нөхөн хангалтаар олгосон гал унтраах тусгай зориулалтын автомашиныг Аврах, гал унтраах анги, нэгжид тавигдах шаардлага MNS 6412:2013

стандартын 7 дугаар зүйлд заасны дагуу төв, орон нутгийн нэр, гал түймэр унтраах аварх ангийн дугаар, албаны бэлэгдэл /лого/, бэхэлгээ түгжээ хийж чанарыг сайжруулах.

5. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нар гал унтраах 3 шатны дасгал, сургуулийг чанаржуулах, гал унтраах мэргэжлийн ур чадварын түвшинг дээшлүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит “Ажил мэргэжлийн тэмцээн”-ийг жолооч, гал сөнөөгч, аврагчдын дунд зохион байгуулах.

#### **Дөрөв: Мэдээ тайлан ирүүлэх талаар:**

Удирдамжит нэгдсэн арга хэмжээний тайлан дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион явуулсан ажлын тайланг 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор бичиг хэргийн стандартын дагуу /Office word/ программ дээр цахим хэлбэрээр, тайланг албан бичгээр 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн дотор Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтэст ирүүлнэ.
- Алба хаагчдыг эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт оруулсан болон гал унтраах үйл ажиллагаанд оролцох явцад бэртэж, гэмтсэн алба хаагчдын судалгаа, холбогдох хууль, дүрэм, журмаар шүүлэг авсан нэгдсэн дүнгийн хуулбар, гал унтраах зориулалтын автомашин, техник, багаж хэрэгсэлд хийсэн засвар үйлчилгээ, “Ажил мэргэжлийн тэмцээн”-ийг зохион байгуулсан илтгэх хуудас тус бүрийг /гарын үсэг/ баталгаажуулж гэрэл зургаар баримтжуулан тайланд хавсаргах.
- Нэгдсэн удирдамжит арга хэмжээний тайланд Гал түймэр унтраах аврах ангийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах чиглэлээр цаашид хийх ажлын талаар санал, хүсэлтийг зайлшгүй тусгасан байх.

#### **Тав: Дүнг танилцуулах**

Нэгдсэн удирдамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайланг хүлээн авч нэгтгэн үр дүнг тооцон, үнэлгээ дүгнэлт өгч, ололт амжилт, зөрчил дутагдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулан ажиллана.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР